



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/126

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 73 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 17,444,086.00 (арван долоон сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга наян зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 73 дугаар сургууль (Ш.Арслан)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 6918 ширхэг нийт 17,444,086.00 (арван долоон сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга наян зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий ном, сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 73 дугаар сургууль (Ш.Арслан)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА





(ד. רפואה) - א. ...
... ..

(ה. רפואה) - ב. ...
... ..
... ..

... ..
... ..

... ..
... ..
... ..
... ..
... ..
... ..
... ..
... ..

... ..
... ..

... ..

